

Аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан

2026 оны 06 сарын 03

Эрдэнэбулган сум

№	Түвшин	Салбар/ ТЕЗ / Хөтөлбөрийн нэр	Үр дүн, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Тайлбар
						он	түвшин						
1	Үндсэн үйл ажиллагаа	АЗДҮАХ-4.9 Санхүү, төсөв хөтөлбөр	Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлнэ	Сургалтанд хамрагдсан хүний тоо	Тоо	2025	290	300	307	2.8	1.6	100%	Тайлант хугацаанд албан хаагчдыг чадавхжуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: Нэгдсэн зөвлөгөөн: 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн аймгийн Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцож, бүх шатны төсөв захирагч, санхүүгийн албаны дарга нарт “Батлагдсан төсвийг зохистой удирдах, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах” сэдвээр илтгэл тавьсан. Чадавхжуулах сургалт: Булган, Ихтамир сумын төсөвт байгууллагуудын албан хаагчид болон аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан сургалтаар сумдын Эрүүл мэндийн төвийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад дотоод хяналтын үр нөлөө, эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт, мэдээлэл хийлээ. Мэргэжил арга зүйн зөвлөгөө: Эрдэнэбулган сумын ЗДТГ, ИТХ, ерөнхий боловсролын 3 сургууль, 2 цэцэрлэгийн удирдлага, дотоод хяналтын багийн гишүүдэд байгууллагын засаглалыг сайжруулах, эрсдэлийг тодорхойлон үнэлэх, эрсдэлд суурилсан хяналтыг төлөвлөх, тайлагнах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

2	Үндсэн үйл ажиллагаа	АЗДҮАХ-4.9 Санхүү, төсөв хөтөлбөр	Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлнэ	Хяналт шалгалтын тоо	Тоо	2025	25	26	10	177.2	165.8	94%	Тайлант хугацаанд хуваарийн дагуу батлагдсан удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт 11 объектоос 5 байгууллага, 3 сумын сангууд (ОНХС, ХХС), өргөдөл хүсэлтээр 1, Сангийн яамны нэгдсэн удирдамжаар 1 хяналт шалгалтыг тус тус зохион байгуулж, эрсдэлтэй үйл ажиллагааг таслан зогсоож ажиллалаа. Хяналт шалгалтуудаар нийт 132.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, улсын байцаагчийн актаар 13.2 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоон, 118.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах 10 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлснээс гадна өмнөх онуудын актын үлдэгдлээс 61.1 сая төгрөгийг нөхөн барагдуулж, Эрдэнэбулган сумын ХХС-д 73.5 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлж, сахилга хариуцлагыг дээшлүүлэн эрсдэлийн түвшинг бууруулж ажиллалаа.
3	Үндсэн үйл ажиллагаа	АЗДҮАХ-4.9 Санхүү, төсөв хөтөлбөр	Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлнэ	Зөвлөмжийн биелэлтийн хувь	Хувь	2025	85	90	85	8.5	8.5	85%	Тайлант хугацаанд Дотоод аудитын хорооны 2, Дотоод аудиторын 19, нийт 21 зөвлөмжийг холбогдох сумд, агентлаг, байгууллагуудад өгч, хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргуулав. Эдгээр зөвлөмжийн үр дүнг 2026 оны сүүлийн хагас жилд улирал тутам үнэлж дүгнэхээр төлөвлөсөн. Мөн 2025 оны дотоод аудитын дүнгээр 15 байгууллагад өгсөн 53 зүйл заалттай зөвлөмжийн биелэлтийг улирал бүр албан бичгээр авч үнэлснээс, бүрэн хэрэгжсэн 45 зөвлөмжийг хяналтаас хасаж ажиллалаа.